ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
2021 ОНЫ 10 ДУГААР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2021.10.22 **Дархан-Уул аймаг**

1. ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Газар зохион байгуулалт, төлөвлөлт, өмчлөлийн чиглэл:

- Дархан-Уул аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2. дахь заалт, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2. дахь заалтын дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 12 дүгээр тогтоол, 2021 оны 16, 20 дугаар зэрэг тогтоолуудаар тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтэнд хяналт тавих, хангах ажлыг зохион байгуулж ажиллаа.

Газар зохион байгуулалт төлөвлөлтийн чиглэлээр:

- 2021 оны 10 дугаар сарын 05 өдөр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас ирсэн 2/1895 тоот албан бичгийн дагуу Газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим систем болох www.egazar.gov.mn, газрын харилцааны цахим шилжилт, эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу төрийн болон аж ахуйн нэгж байгууллагад батлагдсан хуваарийн дагуу танилцуулж, сурталчлах ажлыг зохион байгуулан ажилласан. Тухайн сард нийт 5 байгууллагын 89 албан хаагчдад танилцуулсан байна.
- 2021 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт орсон Дархан сумын 3, 8, 10, 13, 14, 15, Малчин багийн нутаг дэвсгэрт нийт 14 байршлыг газар зохион байгуулалтын төлөвлөлтийн цахим системд оруулсан.

Газар зохион байгуулалтын төлөвлөгөө сурталчлах талаар:

- Дархан-Уул аймгийн 2021 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг сурталчлах ажлыг байгууллагын www.darkhan.gazar.gov.mn цахим хуудас болон фэйс бүүк, www.Egazar.gov.mn цахим хуудсаар иргэн аж ахуйн нэгж байгууллагад ил тод нээлттэй сурталчлах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.
- Тухайн сард www.egazar.gov.mn цахим хуудаснаас 2021 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байршлыг харах зааварыг орон нутгийн телевиз болох TV -12, RJB телевиз, DBS телевизээр иргэн, хуулийн этгээд, олон нийтэд мэдээллйг өгч ажилласан.



*Зураг 1. **Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг иргэд, төрийн байгууллагуудад сурталчилсан***

- Дархан сумын 2022 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд санал өгөх QR кодыг мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтны хамтран бэлтгэж иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад танилцуулсан. Нийт 113 иргэн санал өгсөн байна.



Монгол Улсын иргэнд газар өмчлүүлийн чиглэлээр:

- Дархан-Уул аймгийн хэмжээнд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнээс хойших хугацаанд өмчлүүлсэн газрын судалгааг гаргаж ажилласан. Аймгийн хэмжээнд 2022 онд 445 иргэнд 33,94 га буюу хуучин эзэмшиж байгаа газрыг газрыг өмчлүүлэхээр төлөвлөж аймгийн Иргэдийн төлөөлөгдийн хурлын тэргүүлэгдийн 2021 оны 10 дугаар сарын 01 -ний өдрийн 69 дүгээр тогтоолоор батлагдсан. Тус ажилыг сумын газрын даамлуудтай хамтран зохион байгуулан ажилласан. Өмчлөх эрхээ бусад аймаг, орон нутагт хэрэгжүүлэхээр лавлагааг авсан иргэдийн судалгаа:
- Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд өөрчлөлт орсноос хойш аймгийн хэмжээнд газар өмчлөх эрхээ бусад аймаг, орон нутагт хэрэгжүүлэхээр хүсэлт гаргасан 6 иргэнд лавлагаагаар үйлчилсэн байна.

Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны чиглэлээр:

- Газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгааны дүгнэлтын 3 иргэнд хэвлэж өгсөн.
- Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны тайлан болон дүгнэлтийг Газрын мониторингийн цахим системээр Эхлэх цэг хангай ХХК, Гранд Амур ХХК-ийн хийж гүйцэтгэсэн нийт 28 иргэн, хуулийн этгээдийн тайлан болон дүгнэлтийг цахимаар хүлээн авч шалган захиалгат хянан баталгааны дүгнэлтийг байнгын шинжээчээр баталгаажуулах ажлыг хийсэн. мөн Газрын мониторингийн цахим системээр Үзмон ХХК-ийн хийж гүйцэтгэсэн нийт 14 хуулийн этгээдийн тайлан болон дүгнэлтийг цахимаар хүлээн авч шалган 14 тайлан дүгнэлтийг засуулахаар буцаасан.
- Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийлгэх өмчлөлийн 12, эзэмшлийн 14 иргэнд хянан баталгаа хийлгэх тухай мэдэгдэх хуудсыг хэвлэж өгсөн.



Газрын төлбөр, татварын чиглэлээр:

- Газар эзэмшиж буй 32 иргэн, хуулийн этгээдийн газрын төлбөрийн, 12 иргэний өмчлөлийн газрын татварыг үүсгэж нэхэмжлэлийг хэвлэж өгсөн. Мөн газар эзэмших эрх шилжүүлж буй 17 иргэн, хуулийн этгээдийн газрын дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлж аймгийн татварын хэлтэс руу явуулсан.

Цахим программын чиглэлээр:

- 21 иргэнд egazar.gov.mn цахим системээр газрын газар эзэмших эрх шилжүүлэх, хугацаа сунгах, өмчлөлийн газар худалдах, эзэмшлийн газрыг хэсэгчлэн шилжүүлэх, үлдэгдэл талбайгаан баталгаажуулах, барьцаа бүртгүүлэх, барьцаа чөлөөлөх зэрэг үйлчилгээг цахимаар холбогдох файлуудыг скайнердэж, цахимаар хэрхэн хүсэлтийг явуулах талаар зааж холбогдох файлуудыг илгээсэн.

ЭБАТ:

- Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл тайлбарыг 9 албан тушаалтнаас авч Авлтгатай тэмцэх газрын цахим бүртгэлийн системд бүртгэж оруулсан.



АТГ-ынц ахим бүрдүүлэлтийн системд оруулсан байгаа нь

`

Сонсох ажиллагаа:

- Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2019.06.05-ны өдрийн 41/14 тоот албан шаардлага, Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6-д “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй” 3 иргэн, 6 хуулийн этгээдэд эхний ээлжинд Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагааг хийсэн.

Газрын татвар, төлбөрийн чиглэл:

- Газрын цахим систем нэвтэрсэнтэй холбоотой дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Газрын кадастрын мэдээллийн цахим системийг сурталчлах зорилгоор Дархан хотын 60 жилийн ойн баярт зориулан 60 иргэнд газрын цахим гэрчилгээ бичиж, гэрт хүргэж өгөх ажлыг санаачлан хэрэгжүүллээ. 2021.10.01-ний өдрөөс эхлэн цахим /egazar.gov.mn/-аар өргөдөл хүлээн авч, хэрхэн өргөдлөө цахимаар илгээх мэдээллийг 26 иргэнд өгсөн байна. Цахимаар нийт 17 өргөдлийг хүлээн авсан бөгөөд үүнээс 9 барьцааны өргөдлийг бүртгэж шийдвэрлэсэн, 8 өргөдлийг газрын эрх зүйн харилцааг хянан шийдвэрлэх хурлаал хэлэлцүүлэн шийдвэрлэхээр хүлээгдэж байна.
- Газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулахаар дараах ажлыг зохион байгуулж ажиллаа. Дархан сумын нутаг дэвсгэрт 6 нэгж талбарт газрын дуудлага худалдааг 2021.11.12-ний өдөр зохион байгуулахаар аймгийн Засаг даргын 2021.10.22-ний өдрийн 01-А/292 дугаар захирамж гарсан.
- Мөн 11 нэгж талбарт төсөл сонгон шалгаруулалтаар газар олгохоор аймаг, сумын Засаг даргын 2021 оны 01-А/293, 2021 оны А/132 дугаар захирамж тус тус гарсан байна. Захирамжуудын дагуу дуудлга худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын газрын байршил, мэдээллийг Газрын цахим бирж /www.mle.mn/-д байршуулах ажлыг зохион байгуулж ажиллаж байна.

Геодези, зураг зүйн чиглэл:

- Геодези, зураг зүй, кадастрын зураглалын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй “Гео од”, “Ёлт сүрвэй” ХХК-ний хийж гүйцэтгэсэн **20** ажлыг шалгаж хүлээн авсан.
- Дархан-Уул аймгийн Иргэний танхимд “хаягжилт” болон “газар зүйн нэрийн” талаар материал бэлтгэж Boogii_dframe@yahoo.com цахим хаягаар хүргүүлсэн.
- ДСЦТС ТӨХК-ний эрчим хүчний дамжуулах станцын 79 газрыг хаягийн зурагт оруулж хаяг дугаар олгосон.
- Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнд 350 мод тарих газрын байршлын зургийг хийж улаан шугамыг нь тавьж хүлээлгэн өглөө.

- Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан “ Гудамж, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”-ын нэмэлт өөрчлөлтийн төсөлд /6.6,6.14 дэх хэсэгт/ саналыг №605 тоотоор хүргүүлсэн.
- Газар өмчлөх эрх шилжүүлсэн **21** иргэний бүртгэл хийж **9** амины орон сууцыг кадастрын зурагт оруулсан.
- Хаягийн зургийн дагуу **18** иргэн, **6** аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгосон.

Орхон сум:

- *Газрын харилцаа, газар зохион байгуулалтын чиглэлээр:* Орхон сумын 2021 оны тухайн жилийн төлөвлөгөө болон газартай холбоотой мэдээллийг 123 иргэнд өгч ажиллаа. Газрын өмчлөх, газрын талбай хэмжээ өөрчлөх, зориулалт өөрчлөх, хугацаа сунгах, газар эзэмших эрх шилжүүлэх нийт 38 өргөдлийг шийдвэрлэлээ. 2022 онд иргэнд өмчлүүлэх газрын байршил хэмжээг Сумын ИТХ-ын 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар батлуулсан.
- *Газрын кадастр, бүртгэл чиглэлээр:* Газар эзэмших эрхийн гэрээ гэрчилгээ шинэчлэх хүсэлтэй 16 иргэний газарт Э дугаар авахаар Дархан-уул аймгийн улсын бүртгэл рүү илгээж хүлээн авсан. Газрын гэрээ гэрчилгээ шинэчлэх хүсэлтэй 40 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч үйлчилсэн. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдын 2018 оны 25 тоот тогтоолоор батлагдсан шинэ хаягийн дагуу 5 иргэнд шинэ хаяг өгч ажиллаа. Мөн газрын өргөдлийг цахимаар хүлээн авдаг болсонтой холбоотой цахимаар 6 өргөдөл хүсэлтийг шийдвэрлэсэн. Ноёнхонгор хэсгийн эзэмшлийн зориулалттай газруудад шинээр хаяг дугаар өгч сумын ИТХ-д батлуулахаар зураглалыг ажлыг хийж гүйцэтгэж байна.
- *Газрын төлбөр болон газар эзэмших дуудлага худалдааны чиглэлээр:* Тайлант хугацаанд 26 иргэнтэй газрын төлбөрийн тооцоо нийлсэн. Газрын талбай хэмжээ өөрчлөгдсөн 2 иргэний газарт зохих хууль журмын дагуу дуудлага худалдааны анхны үнийг тооцож төлүүлэх ажлыг хийж хийсэн. Газрын цахим хаяг болох www.mle.mn сайтад газрын барьцаалбар 3 , үнийн мэдээ 2 бүртгэсэн байна. Мөн Төмс хүнсний

ногооны газрын түрээсээр ашиглуулж байгаа 3 иргэнтэй газрын гурвалсан /түрээс/-ийн гэрээ хийсэн.

Шарын гол сум:

- Шарын гол сумын хэмжээнд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргаж Засаг даргад танилцуулж сонсох ажиллагааг эхлүүлсэн. 2022 онд өмчлүүлэх газрын байршил, хэмжээг сумын ИТХ-д танилцуулж, аймгийн ГХБХГазарт хүргүүлсэн.
- 2022 оны тухайн жилийн ГЗБТөлөвлөгөөний саналыг ИААНБ-аас авч байна. Бэлчээрийн газрын фото мониторингийн аргаар үнэлэх ажлын тайланг ГХБХБГазарт хүргүүлсэн. Газар эзэмших эрхийн гэрчилгээ шинэчлэх хүсэлтэй 2 цэцэрлэг, гэрээ гэрчилгээг бусдад шилжүүлэх 2 иргэний цахим хүсэлтийг сумын ЗД-ын захирамжаар мэдээллийн санд өөрчлөлтийг бүртгэсэн. 4 иргэний өмчилсэн газрын талбайг мэдээллийн санд бүртгэсэн.

2. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Барилгын хяналт шалгалт:

- Аймгийн хэмжээнд барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон 13 иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжид угсралтын явцад нь Мэргэжлийн хяналтын газартай хамтран хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн.
- Барилгын хөгжлийн төвөөс ирүүлсэн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон, ашиглалтад орсон барилга байгууламжийн судалгааг Барилга, хот байгуулалтын Сайдын 55 дугаар тушаалын 2, 3 хавсралтын дагуу албан бичгээр хүргүүлсэн.
- Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 157 дугаар тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд хийгдсэн 2021 оны III улиралын тайланг Онцгой байдлын газартай хамтран албан бичгээр Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн.
- Шарын гол сумын Засаг даргаас ирүүлсэн “Шинэ орчин” 71 айлын амины орон сууцны барилгын гадна инженерийн шугамыг ашиглалтад оруулах хүсэлтийн дагуу хянаж үзэхэд гүйцэтгэгч байгууллагын баталгаа дутуу байсан тул боломжгүй тухай албан бичгийг хүргүүлсэн.

Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ:

- Дархан ногоон хот дэд хөтөлбөр батлагдахтай холбогдуулан Дархан-Уул аймагт 20 сая мод тарих болсонтой холбогдуулан мод тарих газрын байршилын зураг төслийг хийж гүйцэтгэсэн.





- ТМ ойл ХХК-ны 9-р багт байрлалтай ШТС, Цагдаагийн газрын буудлагын сургалтын байр, Хонгор сумын Салхит багт баригдах Спорт цогцолборын барилга болон цэцэрлэгийн барилгын архитектор төлөвлөлтийн даалгавар боловсруулж цахимаар олгосон.



- Дархан сумын Засаг даргын багуудаар ажиллаж тулгамдаж буй асуудлын талаар үүрэг даалгавар өгсөний дагуу 3 байршилд үерийн ус зайлуулах, тохижилтын зураг төсөл хийж гүйцэтгэж Дархан сумын Засаг даргад өгсөн.
- Засгийн газрын 2021,07,20 өдрийн 212 дугаар тогтоолын дагуу барилга байгууламж ашиглалтад оруулах дүрэмийн дагуу улсын комисс ажиллаж ашиглалтад оруулсан.
    1. Дархан сумын өргөө багт баригдсан 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга
    2. Дархан сумын 14-р баг Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнд баригдсан хүүхдийн төмөр замын барилга
    3. Дархан сумын 14-р баг Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнд баригдсан алсыг харагч Дархан өргөө политехникийн коллежийн сургалтын дадлагын байрыг ашиглалтад оруулах комиссид оролцсон.

4. Дархан сумын 3-р баг Өсөх баян бүрд хаус ХХК,
5. Барил трейд ХХК-ны гадна цахилгаан хангамжийн эх үүсвэрт холбох ажилд комисс ажиллаж ашиглалтад оруулсан.

- Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагаанд тусгагдсан ГХБХБГ-ын хийж хэрэгжүүлэх ажлын танилцуулга бэтгэж аймгийн удирдлагууд болон инженерийн хангагч байгууллагуудад танилцуулга хийсэн.

- Захиалагчийн хяналт гүйцэтгэх ажлын хүрээнд 14-р баг Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнгийн хөлбөмбөгийн талбай, Дархан сумын 6,7-р багийн гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажил, Дархан сумын 14-р багийн нутаг дэвсгэрт баригдаж байгаа 2200 хүний суудалтай спорт цогцолборын барилгуудад захиалагчийн хяналт гүйцэтгэж хөрөнгө оруулалтын хуралд танилцуулсан.

3. ЗАХИРГАА УДИРДЛАГЫН АЖИЛ:

Хүний нөөц, шагнал урамшуулал:

- “Салбарын шагнал”-д 5 албан хаагчын судалгаа боловсруулж, ДДОТБЗөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж холбогдох материалыг аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэсд хүргүүлсний дагуу Барилга хот байгуулалтын яамны “Жуух бичиг”-ээр С.Дарханбаатар, Б.Золбаясах, Б.Төмөр, Д.Болорцэцэг, “Газрын харилцааны тэргүүний ажилтан” тэмдгээр Б.Баярмаа нарыг шагнасан.

- Дархан хот байгуулагдсаны 60 жилийн ойн өдрүүдэд төр, захиргааны байгууллагад ажиллаж буй ажилтан, албан хаагчдыг аймгийн ТЗУХэлтсээс “ Найрамдалын дархан” тэмдгээр Ч.Анхбаяр, Х.Ролжинжав, Аймгийн ЗД-ын “Жуух бичиг”-ээр Э.Гүрханд, С.Ундрах, Э.Түмэнжаргал, Дархан сумын ЗД-ын “Жуух бичиг”-ээр Ч.Үүрийнтуяа, Э.Түмэнжаргал, “60 жилийн ой медаль”-аар Х.Олонбаяр, Б.Мөнхчулуун,

- Газар зохион байгуулалт,геодези, зураг зүйн газрын “Жуух бичиг”-ээр С.Дарханбаатар, Д.Болорцэцэг, Б.Золбаясах, Б.Төмөр нарыг газрын салбарт үр бүтээлтэй ажилласныг үндэслэн шагнаж урамшуулсан.
- Газрын удирдлагын хэлтсээс Ц.Чулуунцэцэг, Захиргаа удирдлагын хэлтсээс Б.Мөнхзул нар нь шагналын журмын дагуу болзол хангасан тул төрийн дээд шагнал болох “Хөдөлмөрийн хүндэт медаль”-д нэр дэвшүүлж шагнуулхаар ДДОТБЗөвлөлөөр хэлэлцэн дэмжиж, албан тушаалын тодорхойлолт, анкет зэргийг сумын ЗДарга Т.Тулгаад хүргүүлсэн.

Шүүх:

- Нэхэмжлэгч тал болох Дархан сумын 9-р баг, 4 хороолол 4-4 дүгээр байрны оршин суугчдын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.Батцацрал, Б.Жаргалсайхан нэхэмжлэлтэй Захиргааны хэргийн хариуцагчаар Аймгийн ЗД-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Золбаясах, С.Дарханбаатар, Гуравдагч этгээдээр “Минж проперти” ХХК нарт холбогдох хэрэгт Захиргааны хэргийн шүүхийн үзлэг хийж, газар дээр хэмжилт хийсэн. Урьдчилсан хэлэлцүүлэг 2021/10/06-нд болсон, шүүх хуралдаан 14-нд эхэлсэн ч, нэхэмжлэгч талаас Хууль зүйн туслалцаа шаардлагатай тул өмгөөлөгч авхаар шүүх хуралдааныг 10 дугаар сарын 28 хүртэлх хойшлуулж өгнө үү гэсэн хүсэлтийн дагуу дахин хойшлогдсон. Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2021 оны 10 дугаар сарын 22-ны 2/129 тоот Нотлох баримт шаардах тухай албан тоотын дагуу холбогдох нотлох баримтыг гаргаж хүргүүллээ.

Хууль тогтоомж:

- Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021/10/05-ны өдрийн №2/1895 албан тоотын дагуу ирүүлсэн ГЗБГЗЗГДаргын А/187 тоот тушаалаар “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг нийт албан хаагчдад танилцуулсан. Иргэдийн газрын талаарх цахим системийг ашиглахад нь зориулж “**ЦАХИМ ТӨВ**” нээн ажиллуулж заавар зөвлөгөө, өгөх, албан хаагчдын хуваарийг батлан мөрдүүлж ажиллаж байна.



- 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 4-10/1308 албан тоотын дагуу Барилгын тухай хууль, газрын тухай хууль, газрын төлбөрийн тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг албан хаагчдад танилцуулж, саналаа ХЭЗХэлтэсд тус хуультай холбоотой нэмэлт өөрчлөлтийг дэмжиж байгааг тухай албан тоотыг 18-нд хүргүүлсэн.

- Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”, “Төрийн албан хаагчийн анкетын маягт”, “Төрийн албан хаагчийн анкет бичих санамж”, “Албан тушаалын картын маягт”, “Төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдлийн товьёогийн маягт”, “Хувь хүний намтар бичих санамж” журмын төслүүдэд ТАЗөвлөлийн цахим хэлэлцүүлэгт оролцсон.
- Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийг албан хаагчдад танилцуулж, 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хүргүүлхээр хяналтад авсан.

Сургалт:

- “Харилцааны ур чадвар” бичгийн, ярианы ур чадвар, ба биеийн хэлэмж, харилцагчаа сонсох чиглэлээр АШУҮИС-ийн Харилцааны Ур Чадварын тэнхимийн эрхлэгч Др,пр С.Наранчимэг ТАЗөвлөлийн Пүрэв гарагийн Вэбинар сургалтад 2 албан хаагчид цахимаар оролцлоо.

- “Майер Бриггсийн төрөл илтгэгч” хувь хүнийг тодорхойлогч үзүүлэлтийн танилцуулга АНУ-ын Конгрессын номын сангийн мэргэжилтэн Доктор(Ph.D) М.Саруул-Эрдэнэ багш ТАЗөвлөлийн Пүрэв гарагийн Вэбинар сургалтыг хөтлөн явуулсан. 1 албан хаагчид цахимаар оролцлоо.
- “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-ын чиглэлээр аймгийн архивын ерөнхий газраас зохион байгуулсан сургалтад Албан хэрэг хөтлөлт, архивын асуудал хариуцсан ажилтан Ц.Цэнд-Аюуш оролцсон.



- Байгууллагын албан хаагчид Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сургалтаар хичээлийг үзэж, шалгалт өгч сертификатуудаа авлаа.

MERIT Canada

ГЭРЧИЛГЭЭ

Түмэнжаргал Эрдэнэбилэг

ТАНД

Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ

ЦАХИМ СУРГАЛТАД АМЖИЛТТАЙ ОРОЛЦСОН ТУЛ ЭНЭХҮҮ ГЭРЧИЛГЭЭГ ОЛГОВ.

У. БЯМБАСҮРЭН
ЗАСГАЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДЭД ДАРГА
Олгосон: 2021-09-29

ЖЕННИФЕР АДАМС
MERIT ТӨСЛИЙН ЗАХИРАЛ
Дугаар: dvvhqwcmxl

Газартай холбоотой гомдол:

- 2021 оны 087 дугаар сарын 25-ны өдөр аймгийн ЗДаргад хандсан Дархан сумын 10 дугаар багийн 25 дугаар хорооллын оршин суугчдаас ирүүлсэн иргэн Д.Доржпүрэвт холбоотой гомдлыг байгууллагын 2021 оны 10 дугаар сарын 19-ний газрын эрх зүй харилцааны /Захирамж/ хурлаар хэлэлцэн амины орон сууцны зориулалтаар авсан газрын талбайн хэмжээг сунгасан захирамжыг хүчингүй болгож анх байсан 500м2 хэмжээгээр олгуулхаар шийдвэрлэсэн.

Бусад тайлан:

- Төрийн албаны чадавхыг бэхжүүлэх чиглэлээр 2020-2021 онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбрийн мэдээллийг хүснэгтийн дагуу Аймгийн ЗДТГ-т 26-нд хүргүүлхээр хяналтад авлаа.
- 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 2-10/1352 албан бичгийн дагуу аймгийн ЗДТГ-ын ХЭЗХэлтэсээс ирүүлсэн Давхар ажил эрхлэлт, болон ХАСУМ-г АТГ-т хүргүүлж хянуулах, ажилд томилсон байдалд судалгаа хийх, ЭБАТ-ны дэлгэрэнгүй мэдээллийг 2021 оны 10 дугаар сарын 29-нд хүргүүлхээр хяналтад авлаа.

Мэдээлэл технологи, нярав:

Мэдээлэл:

- 70376471 нээлттэй утсаар 29 иргэн, ААНБ-ын асуултанд хариулт өгөв. Дархан-Уул аймгийн ГХБХБГ-ын фэйсбүүк хуудсанд ирсэн 35 иргэний асуултанд хариулав.
- Түргэвчилсэн оношлуурын шинжилгээний бүртгэлийн цэг дээр байгууллагын 2 албан хаагч 2021-10-01, 02, 05, 06-ны өдрүүдэд ажиллав.

- Дархан хотын 60 жилийн ойд зориулан Egazar.gov.mn сайтыг сурталчлан 60 иргэнд гэрчилгээг нь бичиж, гэрчилгээний файлыг өнгөтөөр хэвлэж, хүргэж өгч ажилласан

Мэдээллийн технологийн чиглэлээр:

- Байгууллагын цахим хуудасны “Төрийн үйлчилгээ” цэсэнд “Өргөдлийн загварууд” хэсэг үүсгэж өргөдлийн маягт бөглөх, өргөдөл бичих загваруудыг байрлуулав. Байгууллагын цахим хуудсанд 6 мэдээлэл байрлуулав.





- Дархан-Уул аймгийн 4 сумын газрын даамалд шинээр фэйсбүүк хуудас нээж, даамлуудад мэдээлэл оруулах эрх олгох хүсэлт илгээн, ГЗБГЗЗГ болон аймгийн ГХБХБГ-ын фэйсбүүк хуудсан дээр тавигдсан мэдээллийг даамлуудын хуудсан дээр хуваалцаж, ажлын явцын тухай болон мэдээлэл арга зүйгээр хангаж ажиллаа.





- Фэйсбүүк хуудсан дээр дараах мэдээлэл, “www.egazar.gov.mn цахим систем”-ийг хэрхэн ашиглах талаарх заавар бүхий видео 13 ширхэг бичлэг, 19 ширхэг мэдээлэл оруулж, олон нийтэд сурталчлав.





- Egazar.gov.mn цахим системд нэвтрэхэд туслах гарын авлага, egazar цахим системээр дамжуулан газар өмчлөх, эзэмших эрхтэй холбоотой хүсэлт илгээхэд туслах гарын авлагын эх бэлтгэж, тус бүрийг 10 хувь хэвлэж өгөв. Газрын харилцааны цахим шилжилт, Газрын нэгдмэл сангийн цахим системээр дамжуулан гаргах боломжтой хүсэлтүүдийн жагсаалтын постерийн эх бэлтгэж, хэвлэн иргэд, ААНБ, мэргэжилтнүүдэд тараасан.



- Дархан сумын ТЖГЗБТ-нд санал авах холбоос руу нэвтрэх, Газартай холбоотой хүсэлт илгээхэд бүрдүүлэх материалын жагсаалтыг харах, Газартай холбоотой хүсэлтийн маягтуудыг татаж авах, Хүсэлтийн маягтуудыг бөглөх загвар, гар өргөдөл бичих загваруудыг харах QR код үүсгэж, байгууллагын фэйсбүүк хуудсанд болон постерт оруулав.

egazar android.png | egazar android-500.png | egazar ios.png | egazar ios-500.png | Khongor.png | Orkhon.png

Бусад ажлууд:

- Хонгор сумын газрын даамал Гантуяагийн компьютерийн эвдрэлийг үзэж шалгав. Шинээр ирсэн хорт кодын эсрэг програмыг байгууллагын бүх компьютерт суулгаж, жагсаалтыг агентлаг руу илгээв.
- Windows 10 үйлдлийн системийн update-ийн алдаанаас үүссэн сүлжээгээр хэвлэдэг хэвлэгчүүд хэвлэхгүй байсан 5 компьютерийн алдааг засварлав.



- Орхон сумын газрын даамал, Барилгын материал, үйлдвэрлэл, лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтний компьютерийн үйлдлийн систем цахилгаан тасарсны улмаас гэмтсэн тул форматлаж, хэрэглээний програм, хорт кодын эсрэг програм хангамжуудыг суулгаж, хэвлэгч, сканерыг таниулан, VPN холболтын тохиргоог хийв.

Нярав:

1. 20 ширхэг Нэгж талбарын хувийн хэргийн хавтас нугалж, мэргэжилтнүүдэд олгоход бэлтгэв.
2. Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд дараах үнэт цаас тус тус олгов.

Сумд	Кадастр	Газар эзэмших /Иргэн/	Газар эзэмших /ААНБ/	Газар эзэмших /ТБ/	Газар ашиглах /ААНБ/	НТХХ
Дархан	594	60	5			38
Хонгор	80	30				
Орхон	70					

3. Шаардах хуудсаар 15 төрлийн 51 ширхэг бараа материал олгов.
4. 9-р сарын үнэт цаасны зарцуулалтын болон шаардахаар олгосон бараа материалын нэгтгэлийг гаргаж, ня-бо Мөнхзулд өгөв.
5. 2020 оны ААНБ-ын Улсын тэмдэгтийн хураамжийн тайланг нэгтгэж, үдэж, хавтаслан, хуудас дугаарлаж, архивт хүлээлгэн өгөв.

Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн талаар:

Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн талаар:

ГХБХБГ-т 2021 оны 9 сарын 21-ний өдрөөс 10 сарын 20-ны өдрийн хооронд абле программд нийт 129 албан бичиг /хариутай 102/, 37 өргөдөл /хариутай 21/ ирсэнээс 60 албан бичиг, 14 өргөдөл шийдвэрлэн, 20 албан бичиг, 7 өргөдөл хяналтанд бүртгэжээ.

Албан бичиг, өргөдлийн шийдвэрлэлтийг графикаар харуулбал:

График 1. Албан бичиг, өргөдлийн шийдвэрлэлт, хяналтанд авч судлаж буй талаарх мэдээлэл



Тайлбар: Хариугүй 16 өргөдөл нь тухайн жилийн ГЗБТ-нд санал өгсөн тухай байна.

ЗАХИРГАА, ХУУЛИЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.ЗОЛБАЯСАХ

ХЯНАСАН:

ГАЗРЫН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Г.НЯМДОРЖ